



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/04

Ховд

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах, хэмжээ талбай өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Паламын Цэцэгжаргал /ПЯ63041667/-ийн эзэмшлийн Жаргалант сумын Цамбагарав баг хуучин аймгийн захиргааны байрны зүүн талд байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай 500 метр квадрат газрыг кадастрын мэдээллийн сангийн зургийн дагуу 316 метр квадрат, хаягийг Лааганы 2 дугаар гудамжны 212 тоот болгон өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Жаргалан баг 3 дугаар гудамжны 19 тоотод байрлах Сайнбилэгийн Баясгалан /ПЭ64082916/-ийн худалдаа, үйлчилгээний зориулалттай 190.0 метр квадрат газар, Жаргалан баг 3 дугаар гудамжны 19 а тоотод байрлах 50 метр квадрат газруудыг нэгтгэн кадастрын мэдээллийн сангийн зургийн дагуу 246.0 метр квадрат, хаягийг Орчлон 5 дугаар гудамжны 505 тоот болгон өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилийн хугацаагаар,

3. Шолтойны Арстан /У376032312/-ны эзэмшлийн Жаргалант сумын Наран баг 26 дугаар гудамжны 16 тоотод байрлах гэр бүлийн зориулалттай 1500 метр квадрат газрын хаягийг Орчлон 5 дугаар гудамжны 515 а тоот болгон өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.

4. Газар эзэмших эрх нь сунгагдсан иргэдтэй гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0013

D/Zah-A/04-Bo